





# **АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО**

# **НЭГДСЭН ҮР ДҮН**

Алтай хот  
2017 он

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Говь-Алтай аймгийн Засаг  
Даргын Тамгын газрын *1-р байр*

Утас: 70483442  
Вэб хуудас: [www.govi-altai@nso.mn](http://www.govi-altai@nso.mn);  
[www.1212.mn](http://www.1212.mn)  
Цахим шуудан: [stat\\_altai@yahoo.com](mailto:stat_altai@yahoo.com)



## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ .....  
ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД.....  
ТОВЧИЛСОН ҮГС.....

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИРСЭН ТҮҮХ .. 9

ТООЛЛОГЫН ТУХАЙ ТОВЧ .....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 1998 ОНЫ ТООЛЛОГО .....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2006 ОНЫ ТООЛЛОГО .....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2011 ОНЫ ТООЛЛОГО .....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ ТООЛЛОГО .....

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ..

ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....  
ТООЛЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС.....  
ТООЛЛОГЫН УДИРДЛАГА .....  
ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....  
СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА .....

### ГУРАВДУГААР БҮЛЭГ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ.....

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЙМАГ, .....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРЭЭР.....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР .....  
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР .....  
АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР.....  
ТЭЭВЭР БА АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАР.....  
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ САЛБАР.....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР.....  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН БҮЛГЭЭР.....

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ .....

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ .....  
ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ХЭЛБЭР.....  
ТОЛГОЙ, ОХИН, САЛБАР НЭГЖ.....  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛУЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛДАГ БАЙРНЫ ЭЗЭМШИЛМЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ .....

### ТАВДУГААР БҮЛЭГ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....

АЖИЛЛАГЧДЫН ТОО, ЦАЛИН.....

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО**

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО .....  
ХӨРӨНГӨ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ .....  
ХОРШООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА.....**

ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА .....  
ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, БАЙРШИЛ, ТӨВЛӨРӨЛ.....  
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....  
МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ .....

**ДОЛДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА.....**

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА .....  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ .....  
ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....  
МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ .....

**ХАВСРАЛТ .....**

## ӨМНӨХ ҮГ



Тооллогын үр дүнгийн тайлан нь үндсэн дүнг багтаасан бүлэг, хавсралт хүснэгтүүдээс бүрдэж байна. Тооллогын тайлангийн 1 дүгээр бүлэгт аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг зохион байгуулж ирсэн түүх, 2 дугаар бүлэгт тооллогын эрх зүйн үндэс, удирдлага, зохион байгуулалт, сурталчилгаа зэрэг зохион байгуулалттай холбогдолтой арга хэмжээнүүдийг цогц байдлаар тусгасан бол аж ахуйн нэгж, байгууллагын байршил, төвлөрөл, үйл ажиллагааны төлөв байдлын талаарх гол мэдээллийг 3, 4 дүгээр бүлэгт, 5 дугаар бүлэгт аж ахуйн нэгж, байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг, 6 дугаар бүлэгт төсвийн байгууллагын голлох мэдээлэл, 7 дугаар бүлэгт төрийн бус байгууллагын талаарх мэдээллийг тус тус багтаалаа. Энэ удаагийн тооллогоор аж ахуйн нэгж, байгууллагын байршлын цэгийн газрын зургийн мэдээллийг бүрдүүлж, тайландаа тусгасан.

"Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улс аж ахуйн нэгж, байгууллагын ээлжит тооллогоо 2016 оны 04 дүгээр сарын 01-нээс 04 дүгээр сарын 31-ний өдрүүдэд амжилттай зохион байгуулж явууллаа.

Аж ахуйн нэгж, байгууллагын анхны тооллого улс орон даяар 1991 онд явагдсанаас хойш 6 дахь удаагийн ээлжит тооллогыг амжилттай зохион байгуулж, үр дүнгээ тайлагнаж байгаа бөгөөд эдгээр тооллогын үр дүнгээр эдийн засгийн бүтэц, хөгжлийн чиг хандлага илэрхийлэгдэх суурь мэдээлэл бүрддэг.

Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллого нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлаар нь үнэн зөв тогтоож, улс орны эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, статистикийн судалгаа, түүвэр ажиглалтын хамрах хүрээг бүрэн тогтооход чухал ач холбогдолтой.

Энэ удаагийн тооллогыг онлайн болон уламжлалт аргыг хослуулан явуулсан нь онцлог бөгөөд анхных байлаа.

Энэ удаагийн тооллогыг амжилттай зохион байгуулан явуулахад удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан Үндэсний статистикийн хорооны дарга асан С.Мэндсайхан болон Тооллого, судалгаа, мэдээллийн газрын дарга Б.Ганбат, Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Ш.Жолбарс дарга нарт, тооллогын бэлтгэл зохион байгуулалтыг бүхий л шатанд ханган ажилласан Бүртгэл, тооллого мэдээллийн газрын хамт олон, С.Дуламсүрэн, М.Доржпагам нарт, Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газар, Мэдээлэл, технологийн газар, Хүн ам, орон сууцны тооллогын товчооны болон бүх аймаг, нийслэл, дүүргийн бүртгэл, статистикийн хамт олонд талархал илэрхийлье.

Мөн энэхүү тайланг аймгийн дүнгээр бэлтгэсэн Говь-Алтай аймгийн Статистикийн хэлтсийн дарга Д.Тунгалаг, ахлах мэргэжилтэн Ч.Ууганбаяр, мэргэжилтэн Б.Тогтохбаяр, мэргэжилтэн Г.Батзориг, мэргэжилтэн Г.Цэрэнлхам, гэрээт ажилтан Э.Бямбадулам

нарт талархлаа илэрхийлье.

ҮНДЭСНИИ СТАТИСТИКИЙН  
ХОРООНЫ ДАРГА



А.АРИУНЗАЯА

**ТАЙЛАН БИЧИХЭД ОРОЛЦОГЧИД**

ДҮГЭРЖАВ ТУНГАЛАГ	Статистикийн хэлтсийн дарга
ЧИНЧУЛУУН УУГАНБАЯР	Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
БАДАРЧ ТОГТОХБАЯР	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
ГАНБОЛД БАТЗОРИГ	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
ГАНБОЛД ЦЭРЭНЛХАМ	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
ЭРДЭНЭБИЛЭГ БЯМБАДУЛАМ	Статистикийн хэлтсийн гэрээт ажилтан

## ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНБТ	Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого
ААНБТ-1	Аж ахуйн нэгжийн тооллогын асуулга
ААНБТ-2	Төсвийн байгууллагын тооллогын асуулга
ААНБТ-3	Төрийн бус байгууллагын тооллогын асуулга
ААНБТ-4	Салбар, нэгж, төлөөлөгчийн газрын тооллогын асуулга
ББН	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ГТЕГ	Гааль, татварын ерөнхий газар
ГМС	Газарзүйн мэдээллийн систем
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗБН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
МҮОНРТВ	Монголын үндэсний олон нийтийн радио телевиз
ОАА	Ойн аж ахуй
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТБ	Төсвийн байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗСГ	Эдийн засгийн статистикийн газар
ЭЗҮАСА	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал
ЭЗХТЗ	Эдийн засгийн харилцан туслах зөвлөл
ISIC	International Standard Industrial Classification



1

# АЖ АХУИН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИРСЭН ТҮҮХ

## **АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИРСЭН ТҮҮХ**

### **ТООЛЛОГЫН ТУХАЙ ТОВЧ**

Аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын тооллого нь манай улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлаар нь үнэн зөв тогтоож, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг нь бодитойгоор тодорхойлох, эдийн засгийн хөгжлийн түвшинг харуулах, аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл, байршил, үйл ажиллагааны чиглэлд үндэслэн төр засгийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах мэдээллийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилготой.

Мөн ААНБ-ын тооллогоор бизнес регистрийн сангийн үзүүлэлт, дотоодын нийт бүтээгдэхүүн, нөөц ашиглалтын хүснэгт, үндэсний тооцооны данс, хөрөнгө, хөрөнгө оруулалтын статистик мэдээлэл, төрийн бус байгууллагын үйлдвэрлэл, өрхөд үйлчилдэгашгийн бус байгууллагын хэрэглээг тооцоход шаардлагатай үзүүлэлтүүдийг нэлэнхүйажиглалтаар цуглуулахад чиглэгдсэн.

Манай орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр өмч хувьчлал эрчимтэй явагдаж, төрийн өмчийн аж ахуйн нэгж хувьчлагдаж, хувийн өмчийн аж ахуйн нэгж бий болсноос статистикийн мэдээлэл, судалгаанд шинэ арга хэлбэрийг хэрэглэх, ихэвчлэн түүвэр судалгаа, нэг удаагийн тооллого явуулах, төлөөлөгч нэгжийг сонгож, мэдээлэлд хамруулах зэрэг статистикийн шинжлэх ухааны олон аргуудыг ашиглах шаардлагатай болсон. Иймд, Үндэсний статистикийн хороо нь аж ахуйн нэгж, байгууллагын тооллогыг 1991, 1994, 1998, 2006, 2011, 2016 онуудад улс орон даяар зохион байгуулсан. Аж ахуйн нэгж, байгууллагын 1991, 1994 оны тооллогод эдийн засгийн үйл ажиллагааны зарим хэсгийг хамруулж, тоолох нэгжийн ажиллагчдын тоонд суурилан хязгаар тавьж, цөөнхэдэн үзүүлэлтийг цуглуулж байсан бол 1998 оноос хойш зохион байгуулсан тооллогод өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж ирсэн. Мөн тооллогыг зохион байгуулах үеийн улс орны нийгэм, эдийн засгийн байдал төр, засгийн тогтоол, шийдвэртэй уялдан тооллогын асуулгын хуудасны агуулга өөрчлөгдөж ирсэн.

### **АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 1998 ОНЫ ТООЛЛОГО**

Аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогыг "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 07 дугаар зүйлийн 01 дүгээр заалт, Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 143 дугаар тогтоолын дагуу 1998 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 23-ны хооронд зохион байгуулсан байна. Тооллогыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд бүх аймаг, нийслэл, дүүргийн тооллогод хамрагдвал зохих аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг гаргаж, Үндэсний статистикийн газар (хуучин нэрээр)-аас төлөөлөгч томилон орон нутагт ажиллуулж, зааварэгч, тооллогын асуулгыг аймаг, дүүрэгт нь шалган компьютерт шивж оруулжээ.

Уг тооллогод бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилал (15!С)-ын 2.0 хувилбарыг

## **БҮЛЭГ I. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИРСЭН ТҮҮХ**

нэвтрүүлж, Үндэсний статистикийн газарт бизнес регистрийн санг анх удаа байгуулан, регистрийн сангийн баяжилтыг улирлаар хийх, түүвэр судалгааны хамрах хүрээ болгон ашиглах боломжийг бүрдүүлсэн.Энэхүү тооллогын үр дүнд регистрийн дугааргүй аж ахуйн нэгж, байгууллага, салбарнэгжүүд нэлээд байгааг илрүүлсэн бөгөөд тэдгээрт шинээррегистрийн дугаар олгуулахажлыг хийжээ.Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллогод төв, орон нутгийн 654 хүн дайчлагданажилласны дотроос Үндэсний статистикийн газраас 38 ажилтан аймаг, нийслэл,дүүрэг,сум, баг, хороодод ажиллаж, тооллогын үйл ажиллагаанд 9.2 сая төгрөг зарцуулжээ.

### **АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2006 ОНЫ ТООЛЛОГО**

Аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогоос хойш аж ахуйн нэгж олноор байгуулагдахаас гадна томоохон компаниуд өөрийн охин компани, салбар нэгжүүдийг байгуулж, өргөжин тэлж, улмаар энэхүү нөхцөл байдалтай уялдан аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн төрөл, үйл ажиллагааны талаарх үнэн бодит мэдээллийг бий болгоход ААНБ-ын тооллого явуулах нөхцөл бүрдэж, ААНБ-ын 2006 оны тооллогыг зохионбайгуулсан.ААНБ-ын 2006 оны тооллогыг "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйл;Монгол Улсын Ерөнхий сайдын 2006 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн "Аж ахуйн нэгж,байгууллагын тооллого явуулах" тухай 44 тоот захирамжид үндэслэн 2006 оны 06 дугаарсарын 05-ны өдрийн өглөөний 08.00 цагаас мөн сарын 20-ны өдрийн 21.00 цаг хүртэлзохион явуулсан.

Аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогын хүрээг орон нутагт төлөөлөгч томилонажиллуулан тогтоож байсан бол аж ахуйн нэгж, байгууллагын 2006 оны тооллогын хүрээгтогтооход үндсэн гол мэдээллийн эх үүсвэр нь 1998 оны тооллого болон улирал тутамбаяжилт хийж ирсэн Бизнес регистрийн сан байлаа.

ААНБ-ын 2006 оны тооллогын үр дүнд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төсвийн болон төрийн бус байгууллагаас гадна орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулж,тэдгээрийн үйл ажиллагаанд холбогдолтой бүх талын мэдээллийн санг бүрдүүлжээ.Уг тооллогын эхний 7 хоногт нийт аж ахуйн нэгж, байгууллага, орлогыг нь тухай бүртодорхойлох боломжгүй үйл ажиллагаа эрхлэгчдийн 25.0-30.0 орчим хувь нь тоологдсонбайна.Аймаг, нийслэлийн бүх шатны ажлын хэсгийг өдөр тутмын удирдлагаар хангаж, ажиллахүүрэг бүхий Улсын комиссыг Сангийн сайд, ҮСГ-ын даргын хамтарсан тушаалаар байгуулжажиллууулжээ.Тооллогын өдрүүдэд бүх шатны ажлын хэсгийн гишүүд өдөр бүр өглөөний 09.00 цагаас оройн 11.00 цаг хүртэл жижүүрлэн ажиллаж, урьдчилан зарласан утсаар лавласан асуултболон орон нутагт гарч байсан хүндрэлийн талаарх хариултыг өгч, шуурхай арга хэмжээавч ажилласан байна.

Аж ахуйн нэгж, байгууллагыг тооллогоос орхигдуулахгүй байх үүднээс аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн гэрчилгээний ард тооллогод хамрагдсан болохыг нь гэрчлэх тусгай тэмдэглэгээг хийж, баталгаажуулсан.Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллогод төв, орон нутгийн 685 хүн дайчлагданажиллаж, тооллогын үйл ажиллагаанд 15.2 сая төгрөг зарцуулжээ.

### **АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2011 ОНЫ ТООЛЛОГО**

"Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг; Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн "Аж ахуйн нэгжийн тооллогоявуулах" тухай 61 тоот тогтоолд үндэслэн Аж ахуйн нэгж, байгууллагын 2011 оны тооллогыг 2011 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрүүдэд амжилттай зохион явуулсан. Уг тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын 63.0 хувь нь тооллогын эхний 14 хоногт тоологджээ. Аж ахуйн нэгж, байгууллагын 2011 оны улсын тооллогод эдийн засгийн бүх төрлийн үйлчилгээний олон улсын стандарт ангилал (ISIC)-ын хамгийн сүүлчийн хувилбар (4.0)-ыг нэвтрүүлж, олон улсын стандартад нийцсэн статистик нэгжийг байгуулах суурийг тавьж, тооллогын үр дүнгээр газар зүйн мэдээллийн санг анх удаагаа бүрдүүлж байснаараа онцлогтой болсон.

Тооллогын асуулгад аж ахуйн нэгж, байгууллагын нийт хөрөнгө, мэдээллийн технологийн холбогдолтой үзүүлэлтийг нэмэлт байдлаар дэлгэрэнгүй оруулсан нь тооллогын мэдээллийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлжээ.

Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллогод төв, орон нутгийн 512 хүн дайчлагдан ажиллаж, тооллогын үйл ажиллагаанд 282.0 сая төгрөг зарцуулжээ.

### **АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН 2016 ОНЫ ТООЛЛОГО**

Аж ахуйн нэгж, байгууллагын 2016 оны тооллогыг "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг; Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 163 дугаар тогтоолын дагуу 2016 оны 04-р сарын 01-нээс 05-р сарын 01-ний өдрүүдэд улс орон даяар зохион байгуулсан. ААНБ-ын тооллогын мэдээллийг цуглуулахдаа дараах хоёр аргыг ашигласан. Үүнд: Цахим арга: ААНБ-ын тооллогын цахим хуудас (<http://aanb.nso.mn/login.aspx>)-ыг Гааль, татварын ерөнхий газар (хуучин нэрээр)-ын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2016 оны 01 дүгээр улирлын цахим тайлангийн хуудас (<https://e-tax.mta.mn/portal>)- тай холбож, 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 20-ны өдрүүдэд мэдээллийг цуглуулсан. Уламжлалт арга: Цахимаар тооллогод хамрагдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг 2016 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 30-ны өдрүүдэд тоологч, тооллогын асуулгыг ААНБ-ын удирдлага, бусад холбогдох ажилтанд биеэр танилцуулж, цуглуулжээ. Энэ удаагийн тооллогод уламжлалт цаасан асуулгын хуудсын дагуу мэдээллийг цуглуулдаг байснаас илүүтэйгээр цахим буюу онлайн мэдээллийг бүрдүүлснээрээ ихээхэн ач холбогдолтой болсон. Мөн ААНБ-ын үйл ажиллагаагаа явуулж байгаа байршлын цэгийг бүрдүүлж, газар зүйн мэдээллийн санг шинэчилсэн. Тооллогын асуулгад интернэт захиалга авч, үйлчилгээ үзүүлдэг эсэх, байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал, хөрөнгө оруулалтын мэдээллийг нэмэлт байдлаар цуглуулсан. Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллогод төв, орон нутгийн 1372 хүн дайчлагдан ажиллаж, тооллогын үйл ажиллагаанд 392.1 сая төгрөг зарцуулжээ.



2

## АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН ЗОХИОН

### БАЙГУУЛАЛТ

#### ТООЛЛОГЫН ЭРХ ЗҮЙН ҮНДЭС

"Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндэсний статистикийн хороо нь аж ахуйн нэгжийн тооллогыг 5 жил тутам удирдан явуулна" гэж заасны дагуу 2016 онд 6 дахь удаагийн ААНБ-ын тооллогыг зохион явуулсан.

Түүнчлэн, дараах тогтоол, шийдвэр нь аж ахуйн нэгж, байгууллагын ээлжит тооллого явуулах хууль, эрх зүйн үндэслэл болсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн "Аж ахуйн нэгжийн тооллого явуулах" тухай 163 тоот тогтоол;
- Монгол Улсын Хууль зүйн сайдын 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн "Аж ахуйн нэгж, байгууллагын улсын тооллого явуулах" тухай А/90 тоот тушаал;
- Улсын бүртгэл, статистикийн газар (хуучин нэрээр)-ын даргын 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн "Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого явуулах үзэл баримтлал, асуулга түүнийг нөхөх заавар батлах" тухай А/239 тоот тушаал зэрэг болно.

#### ТООЛЛОГЫН УДИРДЛАГА

Аймгийн Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/104 тоот тушаалаар тооллогыг аймагт зохион байгуулах үүрэг бүхий КОМИСС-ыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

##### **Аймаг, нийслэлийн комисс нь:**

Комиссын дарга - Д.Чинзориг. Эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн бодлого эрхэлсэн орлогч

Комиссын орлогч дарга - Н.Доной . Аймгийн улсын бүртгэл, статистикийн газрын дарга

Гишүүд - П.Золжаргал. Аймгийн ЗДТГ-ын дарга

Х.Баатарзориг. Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ө.Наранбаатар. Аймгийн Татварын хэлтсийн дарга

Д.Бүрэнбаатар. Аймгийн Цагдаагийн газрын дарга

Л.Энхжаргал. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Д.Оюунчимэг. Аймгийн УБСГ-ын бүртгэлийн хэлтсийн дарга

С.Мөнхжаргал. Аймгийн УБСГ-ын статистикийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга.

##### **Д.Тунгалаг. Аймгийн УБСГ-ын статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн**

##### **Сумын ажлын хэсэг:**

Комиссын дарга: Сум засаг дарга, засаг даргын орлогч

Гишүүд:

Улсын бүртгэгч

Санхүү, татварын албаны

жилтан

Багийн засаг дарга нар

ААНБ-ын тооллогыг орон нутагтаа удирдан зохион байгуулах, тооллогын явц болон

## БҮЛЭГ II. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

тулгарч буй асуудлын талаар ажлын хэсэгт мэдэгдэж байх, холбогдох арга хэмжээ авч, ажиллах үүрэг бүхий аймаг, нийслэл, сум, дүүргийн комисс, ажлын хэсгийг тухайн шатны Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулсан.

Тооллогыг илүү үр дүнтэй, олон улсын стандартад нийцэхүйц байлгах үүднээс тооллогын

үзэл баримтлал, асуулга, түүнийг нөхөх заавар, зохион байгуулалтын бусад асуудлаар олон улсын байгууллагын төслийн шугамаар ажилласан зөвлөх, мэргэжилтний зөвлөмж,

саналыг авч ажилласан.

### **ТООЛЛОГЫН БЭЛТГЭЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Монгол улсын Статистикийн тухай хуулийн 7-р зүйлийн 7,1 дэх хэсгийн "з", Монгол улсын Засгийн газрын 2016 оны 163 дугаар тогтоол, Хууль зүйн сайдын 2016 оны А/90 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2016 оны А/104 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн 18 сумын улсын бүртгэл, статистикийн ажилтнууд болон санхүү төрийн сангийн албаны дарга, гэрээт тоологч нар зэрэг 40 гаруй хүн оролцсон сургалтыг аймгийн Улсын бүртгэл, статистикийн газраас энэ 4 сарын 1-ны өдөр Алтай хотод аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд зохион байгууллаа.

Сургалтаар тооллого явуулах эрх зүйн үндэс, зохион байгуулалт, тооллогыг явуулах аргачилсан зөвлөмж, зааврын талаар тус газрын удирдлага, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд тайлбарлан сурталчилсан байна.

Сургалтын явцад статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд " Анхан шатанд статистик мэдээ, мэдээллийг бэлтгэх, дамжуулах талаар" сэдэвт хичээлийг сургалтанд оролцогчдод зааж, гарын авлага, материалаар хангасан нь үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Мөн тооллогын талаарх зар, сурталчилгааг орон нутгийн нийт иргэдэд аймгийн "Миний нутаг " телевизээр дамжуулан өгсөн байна.

Тооллогод хамрагдсан эсэхэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллага бүрд "ТООЛОВ" гэсэн гэрчилгээ цахим болон цаасан хэлбэрээр олгож, баталгаажуулж ажилласан. Түүнчлэн, тооллогод ажиллах тоологчдод ажлын үнэмлэх олгох, тооллогын материалыг гээж үрэгдүүлэхгүй байх зорилгоор тусгайлсан хавтас бэлтгэж, хүргүүлэх зэргээр бэлтгэл ажлыг хангаж ажиллав.

Тооллого явагдах хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монгол улсын Статистикийн тухай хуулийн 7-р зүйлийн 7,1 дэх хэсгийн "з", Монгол улсын Засгийн газрын 2016 оны 163 дугаар тогтоол, Хууль зүйн сайдын 2016 оны А/90 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2016 оны А/104 дугаар захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд Говь-Алтай аймгийн хэмжээнд тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2016 оны 3 сарын 31-ны өдрийн А/104 тоот захирамжаар байгуулан ажиллалаа.

Захирамжаар ажлын хэсгийн бүрлэхүүн, ажлын удирдамжийг баталж нийт сумдад хүргүүлсэн бөгөөд сумдын түвшинд тооллогын ажлыг зохион байгуулах салбар комиссуудыг бүх сумын Засаг даргын захирамжаар байгуулж ажиллуулсан болно.

Мөн аймгийн салбар комиссын даргаар тооллогын ажлыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтэнд нь гишүүд хяналт тавьж ажилласан нь үр дүнтэй арга хэмжээ болсныг энд цохон тэмдэглэж байна.

Аж ахуйн нэгжийн тоо харьцангуй олонтой аймгийн төвийн Есөнбулаг суманд 2 тоологчийг түр хугацаанд авч ажиллуулж уламжлалтаар тоологдох байгууллагуудыг

## БҮЛЭГ II. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

тоолуулснаас гадна Есөнбулаг сумын ЗДТГ-ын бүтцэд статистикийн асуудал хариуцсан мэргэжилтнийг дагнан ажиллуулдаг нь тооллогод үр дүнгээ өгсөн юм.

Сумдын тооллогын явц, дүн, илтгэх хуудсыг хүлээн авах болон шивэх, кодлох ажлыг аймгийн статистикийн хэлтсийн 4 мэргэжилтэн, гэрээт ажилтан нарт хариуцуулсан аймгийн УБСГ-ын даргын тушаал гарган хэрэгжилтэнд хэлтсийн дарга миний бие хяналт тавьж ажилласан бөгөөд энэ хугацаанд ямар нэг зөрчил гараагүй болно.

Тооллогонд УБСЕГ-аас өгсөн хүрээгээр нийт 961 ААНБ тоологдохоор манай аймгийн тухайд товлогдсоноос графикт хугацаанд буюу 4 сарын 4-ны өдрөөс 4 сарын 29-ныг дуустал хугацаанд хүрээнд орсон байгууллагуудаас дараахь шалтгаанаар

Үүнээс Татан буугдсан	11
Эзэн нь нас барсан	2
Хаяг, утас тодорхойгүй буюу аймгаас хайгаад олдоогүй	7
Давхар регистртэй	1
Нууцын зэрэглэлтэй	4

Бусад буюу үйл ажиллагаа явуулаагүй, аймгийн татварын хэлтэст татан буугдахаар материал нь бүрдсэн

10

зэрэг нийт 36 байгууллага тооллогонд хамрагдаагүй болно.

Ингээд үлдсэн 925 байгууллага нь тооллогонд хамрагдаж тоологдсон болно.

Тооллогонд хамрагдсан жагсаалтаас тооцоход :

Аж ахуйн нэгж, байгууллага	636
Төрийн байгууллага	180
Төрийн бус байгууллага, сан холбоо	75

Салбар нэгж 34 тус тус тоологдлоо.

Тооллогын явцад тохиолдсон үндсэн бэрхшээл бол аж ахуйн нэгж байгууллагууд бүртгэлийн гэрчилгээнд байдаг хаягтаа байхгүй, дарга, захирал нарын утас нь холбогдохгүй, эсвэл солигдсон зэрэг асуудлууд байлаа.

Мөн шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй байх, зарим байгууллагууд бүртгүүлснээс хойш үйл ажиллагаа явуулаагүй, сураг тасарч алга болсон, татварын байгууллагад тайлан гаргадаггүй, бүртгэгчтэй ямар ч холбоогүй болсон тохиолдлууд нилээд гарч байлаа.

Тооллогын мэдээллийг цуглуулсны дараа авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Аж ахуйн нэгж, байгууллагын тооллогын материалыг компьютерт шивэх, шалгах, засварлах програм хангамжид зориулан бодлогын даалгавар, мэдээлэл боловсруулах програм хангамжийг боловсруулж, туршилтыг хийж, орон нутагт шивэлтийн ажлыг зохион

байгууллаа. Тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг газрын зурагт тэмдэглэж, мэдээллийн сан бүрдүүлж, цаашид тооллого, судалгааны хамрах хүрээг бодитой тодорхойлоход голлох үүрэг гүйцэтгэхээр боллоо. ААНБ-ын тооллогод хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг шалтгаанаар нь нэгтгэж бэлтгэсэн нь тооллогын үр дүнд аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийг цэгцлэх арга хэмжээний чухал мэдээлэл болсон.

### **СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА**

Аймгийн 18 сумын улсын бүртгэл , статистикийн ажилтнууд болон санхүү төрийн сангийн албаны дарга, аймгийн төвийн тоологч зэрэг 40 гаруй хүн оролцсон сургалтыг аймгийн Улсын бүртгэл, статистикийн газраас энэ 4 сарын 1-ны өдөр Алтай хотод аймгийн ЗДТГ-ын хурлын танхимд зохион байгуулсан.

Сургалтаар тооллого явуулах эрх зүйн үндэс, зохион байгуулалт, тооллогыг явуулах аргачилсан зөвлөмж, зааврын талаар тус газрын сургагч багшаар бэлтгэгдсэн 2 хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүд тайлбарлан сурталчилсан бөгөөд шаардагдах маягтуудыг тооллогын хүрээг үндэслэн олшруулан хэвлэж , бүх сумдын бүртгэл ,статистикийн ажилтнуудад хүргүүлж хангаж ажиллалаа.

Сургалтын явцад мөн статистикийн хэлтсийн мэргэжилтнүүд " Анхан шатанд статистик мэдээ, мэдээллийг бэлтгэх, дамжуулах талаар" сэдэвт хичээлийг сургалтанд оролцогчдод зааж, " Статистик мэдээлэгчийн гарын авлага", материалаар хангасан юм.

Мөн тооллогын талаарх зар, сурталчилгааг орон нутгийн нийт иргэдэд аймгийн "Миний нутаг " телевизээр 3 удаа , аймгийн Алтай орон нутгийн радиогоор 1 удаа, болон аймгийн төв талбайн видео дэлгэцээр тус тус дамжуулан тогтмол өгч байна.





3

**АЖ АХУЙН НЭГЖ,  
БАЙГУУЛЛАГЫН  
ТОО,  
БАЙРШИЛ**

## АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, АЙМГААР

Аж ахуйн нэгж, байгууллагын тоо нь аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрлийг харуулах голзүүлэлт бөгөөд газар зүйн бүс нутгаар нэлээд ялгаатай байдаг.

Аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөлд хүн амын шилжих хөдөлгөөн, хүн амын нягтрал шууд нөлөөлж байгаа хэдий ч засаг захиргаа, байгаль, цаг уур болон газар зүйн байршлаасмөн хамаарч байна.

Иймд, аж ахуйн нэгж, байгууллагын үндсэн үзүүлэлтийг байршлаар тодорхойлох зорилгоорэнэ удаагийн тооллогод газарзүйн мэдээллийн системийг бүрдүүлсэн.

Газар зүйн мэдээллийн систем нь аж ахуйн нэгж, байгууллагынтооллогын нэгжийн байршлыгтодорхойлохоос гадна тооллого, судалгааны нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлох, ажахуйн нэгж, байгууллагыг тооллогод бүрэн хамруулахад чухал ач холбогдолтой байлаа.


ААНБ нь газар зүйн мэдээллийн системийг ашиглан цахим кадастрын зураг дээр газрын зургийн програмын тусламжтайгаар байршлаа тодорхойлсон.

ААНБ-ын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо, гудамж, хороолол, байр, хаалганы дугаар, бүсчлэлийн код зэрэг хаягийн үзүүлэлтийг ашиглан дараах 3 аргаар байршлыг тодорхойлсон. Үүнд:

1. Бүртгэлд суурилсан онлайн тооллогод хамрагдсан ААНБ нь цахим кадастрын зурагтгазрын зургийн програмын тусламжтайгаар байршлаа тодорхойлсон.
2. Хэвлэмэл буюу цаасан асуулгаар мэдээллийг цуглуулсан ААНБ-ын байршлыг интернэтэд холбогдсон сумдад тоологч онлайн програмд байршлын тэмдэглэгээ хийсэн.
3. Интернэтэд холбогдоогүй сумдад тоологч хэвлэмэл газрын зурагт ААНБ-ын байршлыгтэмдэглэж, аймаг, дүүргийн комисс болон ажлын хэсэгт хүлээлгэн өгч, аймаг, дүүрэгтажиллаж байгаа тоологч онлайнгаар газрын зурагт тэмдэглэгээг хийсэн.

Аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны тооллогод 496, 2006 онд 528, 2011 онд 588 ААНБ хамрагдаж байсан бол 2016 онд 920 ААНБ хамрагджээ.

### ЗУРАГ 3.1 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА




Сүүлийн 5 жилийн хугацаанд Говь-Алтай аймгийн аж ахуйн нэгж, байгууллага 332 нэмэгджээ. Энэ нь хэдийгээр аж ахуйн нэгж, байгууллагын тооны өсөлт боловч цаад

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

агуулгаараа манай аймгийн эдийн засгийн цар хүрээ өргөжин тэлж байгааг харуулж байна.

ЗУРАГ 3.2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, 2016 ОН, байгууллагын төрлөөр



Энэ удаагийн 2016 оны тооллогод хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагыг төрлөөр нь авч

үзэхэд, нийт 920 аж ахуйн нэгж, байгууллагын 663 нь буюу 72.1 хувь нь аж ахуйн нэгж, 78 буюу 8.5 хувь нь төрийн бус байгууллага, 179 буюу 19.5 хувь нь төсвийн байгууллага байна.

Аж ахуйн нэгж, байгууллага нь салбар/төлөөлөгчийн газрыг байгуулах замаар үйл ажиллагаагаа өргөтгөх эсвэл охин, хараат компани байгуулж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаагаа тэлэх хандлагатай байгаа нь харагдаж байна.

Иймд, өмнөх тооллогын нэгэн адил аж ахуйн нэгжийн салбар, охин, хараат компани хоорондын уялдааг нарийвчлан тогтоосон бөгөөд тооллогын дүнгээр нийт хамрагдсан 886 хуулийн этгээд нь 34 салбар нэгж байгуулж, 1 нь охин, хараат компанитай

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

#### ХҮСНЭГТ 3.1. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, тооллого явагдсан он, сумаар

Сум	1998	2006	2011	2016	$\frac{2016}{1998}$ %	$\frac{2016}{2006}$ %	$\frac{2016}{2011}$ %
<b>Бүгд</b>	<b>488</b>	<b>528</b>	<b>588</b>	<b>920</b>	<b>1.9</b>	<b>1.7</b>	<b>1.6</b>
Есөнбулаг	214	225	264	472	2.2	2.1	1.8
Алтай	18	19	18	22	1.2	1.2	1.2
Баян-Уул	9	16	14	22	2.4	1.4	1.6
Бигэр	12	21	21	30	2.5	1.4	1.4
Бугат	31	18	16	27	0.9	1.5	1.7
Дарив	12	13	20	22	1.8	1.7	1.1
Дэлгэр	20	31	39	43	2.2	1.4	1.1
Жаргалан	13	15	17	25	1.9	1.7	1.5
Тайшир	12	16	16	20	1.7	1.3	1.3
Тонхил	13	15	19	22	1.7	1.5	1.2
Төгрөг	17	16	14	24	1.4	1.5	1.7
Халиун	13	16	20	30	2.3	1.9	1.5
Хөхморьт	13	18	17	22	1.7	1.2	1.3
Цогт	26	33	32	49	1.9	1.5	1.5
Цээл	19	16	15	21	1.1	1.3	1.4
Чандмань	21	14	15	22	1.0	1.6	1.5
Шарга	12	16	19	26	2.2	1.6	1.4
Эрдэнэ	13	10	12	21	1.6	2.1	1.8

Аймгийн төвийн сум болох Есөнбулаг сумд аж ахуйн нэгж, байгууллагын төвлөрөл ихтэй байгаа нь харагдаж байна.

#### ХҮСНЭГТ 3.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД, тооллого явагдсан он, байгууллагын төрлөөр

Он	Бүгд	Байгууллагын төрөл		
		Аж ахуйн нэгж	Төсвийн байгууллага	Төрийн бус байгууллага
1998	476	285	184	7
2006	433	261	157	15
2011	520	305	175	40
2016	886	634	177	75

Хуулийн этгээд аж ахуйн нэгж нь 2016 оны тооллогоор 634 болж, өмнөх тооллогоос 329 буюу 2.1 дахин, төсвийн байгууллага 177 болж, өмнөх тооллогоос 2 буюу 1.1 хувиар, төрийн бус байгууллага 75 болж, өмнөх тооллогоос 35 буюу 87.5 хувиар нэмэгджээ.

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

#### ХҮСНЭГТ 3.3. ХУУЛИЙН ЭТГЭЭД, сум, тооллого явагдсан оноор

Сум, дүүрэг	1998		2006		2011		2016	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	468	98.2	433	100	520	100.2	886	100.1
Есөнбулаг сум	201	42.2	175	40.4	236	45.4	439	49.5
Алтай сум	17	3.6	16	3.7	15	2.9	22	2.5
Баян-Уул сум	9	1.9	12	2.8	12	2.3	22	2.5
Бигэр сум	12	2.5	16	3.7	19	3.7	30	3.4
Бугат сум	30	6.3	15	3.5	14	2.7	27	3
Дарив сум	12	2.5	12	2.8	18	3.5	22	2.5
Дэлгэр сум	20	4.2	29	6.7	36	6.9	43	4.9
Жаргалан сум	12	2.5	13	3	15	2.9	25	2.8
Тайшир сум	12	2.5	13	3	14	2.7	20	2.3
Тонхил сум	12	2.5	11	2.5	17	3.3	22	2.5
Төгрөг сум	17	3.6	14	3.2	11	2.1	24	2.7
Халиун сум	11	2.3	15	3.5	18	3.5	30	3.4
Хөхморьт сум	13	2.7	15	3.5	15	2.9	22	2.5
Цогт сум	25	5.3	27	6.2	29	5.6	49	5.5
Цээл сум	19	4	14	3.2	12	2.3	21	2.4
Чандмань сум	21	4.4	13	3	13	2.5	22	2.5
Шарга сум	12	2.5	15	3.5	17	3.3	25	2.8
Эрдэнэ сум	13	2.7	8	1.8	9	1.7	21	2.4

Хуул

ийн этгээдийн тооны өсөлтийн хувийг сумаар авч үзвэл, Есөнбулаг, Алтай, Бугат, Тонхил, Төгрөг, Цээл, Чандмань, Эрдэнэ сумдадт 2006 онд 1998 оны тооллогоос хуулийн

этгээдийн тоо буурч байсан бол 2016 оны тооллогоор бүх сумдад хуулийн этгээдийн тоо нэмэгдсэн байна.

ААНБ-ын 2016 оны тооллогод хамрагдсан хуулийн этгээдийн тоог өмнөх тооллогын дүнтэй

харьцуулахад Эрдэнэ, Төгрөг сумдад 2.2-2.3 дахин, Бугат, Есөнбулаг, Баян-Уул, Цээл, Чандмань, Цогт сумдад 69.0-92.9 хувь, Халиун, Жаргалан, Бигэр, Шарга, Хөхморьт, Алтай сумдад 46.7-66.7 хувь, Тайшир, Тонхил, Дарив, Дэлгэр сумдад 19.4-42.9 хувиар өсжээ (Хавсралт хүснэгт 2).

#### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРЭЭР

Аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай

нөхөрлөл (ББН), зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл (ЗБН), хоршоо, хувьцаат

компани (ХК), хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК), төрийн өмчит үйлдвэрийн газар (ТӨҮГ), орон нутгийн өмчит үйлдвэрийн газар (ОНӨҮГ), төсвийн байгууллага (ТБ), төрийн бус байгууллага (ТББ) гэж ангилдаг. Бусад гэсэн ангилалд ХЭАА болон сургууль гэх мэт байгууллагыг хамрууллаа.

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

Энэ хэсэгт аж ахуйн нэгж, байгууллагыг хариуцлагын хэлбэрээр ангилж, тооллогын үр дүнг танилцуулж байна.

#### ХҮСНЭГТ 3.4. ХУУЛИЙН ЭТГЭЭД, тооллого явагдсан он, хариуцлагын хэлбэрээр

Хариуцлагын хэлбэр	1998	2006	2011	2016	2016	
					2006 %	2011 %
Бүгд	476	433	520	886	204.6	170.0
ХК	4	4	4	3	75.0	75.0
ХХК	93	135	194	479	354.8	246.9
Хоршоо	99	84	70	114	135.7	162.9
Нөхөрлөл	13	27	27	28	103.7	103.7
ТӨҮГ, ОНӨҮГ	13	11	10	10	90.9	100.0
ТББ	7	15	40	75	500.0	187.5
Төсвийн байгууллага	184	157	175	177	112.7	101.1
ХЭАА	63	0	0	0	0	0

Тооллогод хамрагдсан хуулийн этгээдийн 479 буюу 54.1 хувь нь ХХК, 75 буюу 8.5 хувь нь ТББ, 177 буюу 20.0 хувь нь төсвийн байгууллага, 114 буюу 12.9 хувь нь хоршоо, 28 буюу 3.2 хувь нь нөхөрлөл, 10 буюу 1.1 хувь нь ТӨҮГ болон ОНӨҮГ, 3 буюу 0.3 хувь нь ХК байна.


#### ХҮСНЭГТ 3.5. ХУУЛИЙН ЭТГЭЭД, 2016 ОН, хариуцлагын хэлбэр, сумаар

Сум	Хариуцлагын хэлбэр							
	Бүгд	ХК	ХХК	Хоршоо	Нөхөрлөл	ТӨҮГ, ОНӨҮГ	ТББ	Төсөвт байгууллага
Бүгд	886	3	479	114	28	10	75	177
Есөнбулаг сум	439	2	300	18	11	7	42	59
Алтай сум	22		10	6			1	5
Баян-Уул сум	22		11	2	2		1	6
Бигэр сум	30		12	5	2		5	6
Бугат сум	27		13	5			1	8
Дарив сум	22		9	4	1	1	1	6
Дэлгэр сум	43		17	12	2		1	11
Жаргалан сум	25		6	9	1		3	6
Тайшир сум	20		9	2	2		1	6
Тонхил сум	22		10	2			3	7
Төгрөг сум	24		11	5			2	6
Халиун сум	30		9	9	1		4	7
Хөхморьт сум	22		10	3			2	7
Цогт сум	49	1	19	13	2		1	13
Цээл сум	21		9	4			2	6
Чандмань сум	22		8	7			1	6
Шарга сум	25		8	4	4	1	2	6
Эрдэнэ сум	21		8	4		1	2	6

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

Хязгаарлагдмал хувьцаат компанийн дийлэнх нь аймгийн төвийн сум буюу Есөнбулаг сумд байрлажээ.

**ЗУРАГ 3.3. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРИЙН БҮТЦЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ, 2016 ОН, өмнөх тооллогын дүнгээс, пунктээр**



Өмнөх тооллогын дүнгээс хойш хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрийн бүтцэд гарсан өөрчлөлтийг авч үзвэл, 2011 оны тооллогоор хуулийн этгээдийн дүнд төрийн бус байгууллага 7.7 хувийг эзэлж байсан бол 2016 онд 8.5 хувийг эзэлж, 0.8 пунктээр өссөн байна. 2011 оны тооллогын дүнгээс хязгаарлагдмал хувьцаат компанийн тоо 16.8 пунктээр өссөн бол хоршоо 0.6 пункт, ТӨҮГ болон ОНӨҮГ 0.8 пункт, ХК 0.4 пункт, нөхөрлөл 2.0 пункт, төсвийн байгууллага 13.7 пунктээр буурчээ.

### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Эдийн засгийн хамрах хүрээ тэлж, жилээс жилд ААНБ-ын тоо нэмэгдэж байгаа тул ААНБ-ын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг нарийвчлан тогтоож, салбарын түвшинд, орон нутгийн түвшинд болон ААНБ-ын түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргахад хэрэгцээтэй мэдээллийг гаргахыг зорилоо.

Аж ахуйн нэгж, байгууллагын 2016 оны тооллогод ААНБ-ын үйл ажиллагааны чиглэлийг тогтооход Сангийн сайдын 103 тоот тушаалаар 2011 оны 04-р сарын 29-ний өдрийн баталсан “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал” (ISIC) хувилбар 4.0-ыг ашигласан.

Хуулийн этгээдийн тоог эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, үйлчилгээний салбарын хуулийн этгээдийн тоо 169 буюу 26.7 хувь, худалдааны салбарынх 267 буюу 42.1 хувь, барилгын салбарынх 42 буюу 6.6 хувь, аж үйлдвэрийн салбарынх 76 буюу 12.0 хувь, ХАА-н салбарынх 80 буюу 12.6 хувийг эзэлж байна.

Аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд 2016 онд өмнөх тооллогоос 59.7 хувиар, үйлчилгээний чиглэлийнх 77.2 хувиар, худалдааны чиглэлийнх

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

79.3 хувиар, ХАА-н чиглэлийнх 85.8 хувиар, барилгын чиглэлийнх 2.6 дахин нэмэгджээ. Хуулийн этгээдэд худалдаа болон үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувийн жин өндөр хэвээр буюу нийт хуулийн этгээдийн 80.0 орчим хувийг эзэлж байна.

#### ХҮСНЭГТ 3.6. ХУУЛИЙН ЭТГЭЭД, 2011, 2016 ОН, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

	2011					2016					
	Бүгд	ХАА	Аж үйлдвэр	Худалдаа	Үйлчилгээ	Бүгд	ХАА	Аж үйлдвэр	Барилга	Худалдаа	Үйлчилгээ
<b>Бүгд</b>	<b>37</b>	<b>11</b>	<b>7</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>185</b>	<b>32</b>	<b>26</b>	<b>15</b>	<b>77</b>	<b>35</b>
Үйл ажиллагаагаа эхлээгүй	3	1		1	1	49	10	6	5	16	12
Үйл ажиллагаагаа түр зогссон	13	3	3	3	4	67	8	9	5	30	15
Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр дутагдалтай	11	3	1	4	3	39	8	5	4	20	2
Ажлын байргүй						1					1
Ажлын туршлага, зохион байгуулалт хангалтгүй	1				1						
Үйл ажиллагаа нь бүрэн зогссон	5	3		1	1	19	4	4		7	4
Бусад	4	1	3			10	2	2	1	4	1

#### ХҮСНЭГТ 3.7. АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ БАЙРНЫ ЭЗЭМШИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, БАЙРНЫ ЭЗЭМШЛИЙН ТӨРЛӨӨР

ЭЗҮАА	2011				016				
	Бүгд	Өөрийн эзэмшлийн	Түрээсийн	Бусад	Бүгд	Өөрийн эзэмшлийн	Түрээсийн	Бусад	Тогтсон байргүй
	<b>305</b>	<b>140</b>	<b>37</b>	<b>128</b>	<b>634</b>	<b>439</b>	<b>49</b>	<b>11</b>	<b>135</b>
ХАА	56	17	5	34	80	37		1	42
Аж үйлдвэр	49	24	6	19	76	53	10	3	10
Барилга	18	9	3	6	42	27	3	1	11
Худалдаа	79	43	9	27	267	205	14	3	45
Үйлчилгээ	103	47	14	42	169	117	22	3	27

#### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, АЖИЛЛАГЧДЫН ТООНЫ БҮЛГЭЭР

Ажиллагчдын тоо нь ААНБ-ын үйл ажиллагааны цар хүрээ, чадамжийг илэрхийлэх гол үзүүлэлтийн нэг юм. Иймд, ААНБ-ын 2016 оны тооллогоор 2015 онд үйл ажиллагаа явуулсан ААНБ-аас ажиллагчдын тооны мэдээллийг цуглуулсан тул ажиллагчдын тооны үзүүлэлтийг 2015 онд үйл ажиллагаа явуулсан хуулийн этгээдийн түвшинд бүлгээр ангилан авч үзлээ.

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

ХҮСНЭГТ 3.8. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ажиллагчдын тоо, хүйсээр тооллого явагдсан оноор

	2006			2011			2016		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
АЖИЛЛАГЧДЫН ТОО	4733	2149	2584	5959	2590	3369	6861	3159	3702

Үйл ажиллагаа 2015 онд явуулсан хуулийн этгээдийн тоог ажиллагчдын тоо 6861 байна. Үүнээс 54.0 хувийг эмэгтэйчүүд эзлэж байна.


ХҮСНЭГТ 3.9 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ТҮҮНД АЖИЛЛАГЧДЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, 2011, 2016 ОН

ЭЗҮЯА 4.0	2011		2016	
	ААНБ	Ажиллагчид	ААНБ	Ажиллагчид
	483	5959	678	6861
ХАА	45	287	47	194
Аж үйлдвэр	42	375	53	731
Барилга	18	460	29	343
Худалдаа	70	217	196	506
Үйлчилгээ	308	4620	353	5087

### АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН БҮЛГЭЭР

Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, чадамжийг тодорхойлох гол үзүүлэлтийн нэг нь ажиллагчдын тооноос гадна борлуулалтын орлого байдаг. Энэ бүлэгт аж ахуйн нэгж, байгууллагын тоог 2015 онд үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын борлуулалтын орлогын бүлгээр авч үзлээ.

ЗУРАГ 3.4. АЖ АХУЙН НЭГЖИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, САЯ ТӨГРӨГӨӨР, 2005, 2010,



### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

#### ХҮСНЭГТ 3.10. АЖ АХУЙН НЭГЖИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, ӨМЧИЙН ТӨРӨЛ, САЯ ТӨГРӨГӨӨР, 2005, 2010, 2015 ОН

Өмчийн хэлбэр	1998		2006		2011		2016	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Нийт	496	100	7925.5	100	16702.1	100	33649.4	100
Төрийн	38	7.7	7.9	0.1	985.3	5.9	7091.1	21
Орон нутгийн			1606.5	20.3	1213	7.3	1330	4
МУ-ын иргэний хувийн	446	89.9	6300.6	79.5	14484.2	86.7	25228.3	75
Хувийн гадаадтай хамтарсан	12	2.4	10.5	0.1	19.6	0.1		
Гадаад улсын			0	0				


#### ХҮСНЭГТ 3.11 АЖ АХУЙН НЭГЖИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, 1998, 2005, 2010, 2015 ОН

ЭЗҮАА 3.1	1998		2006		2011		2016	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Нийт	496	100	7925.5	100.1	16702.1	100	33649.4	100
ХАА	45	9.1	76.5	1	382.4	2.3	641.3	1.9
Аж үйлдвэр	123	24.8	5702.9	72	3075.3	18.4	13352.7	39.7
Барилга	15	3	639.5	8.1	6995.2	41.9	6632.4	19.7
Худалдаа	229	46.2	1205.6	15.2	4616.3	27.6	8853.9	26.3
Үйлчилгээ	84	16.9	301	3.8	1632.9	9.8	4169.1	12.4

#### ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР


Хөдөө аж ахуйн салбарыг газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл; ан агнуур болон түүнд туслах үйл ажиллагаа; ойн аж ахуй, мод бэлтгэл; загас агнуур, үржүүлэг зэрэг дэд салбараар ангилж, мэдээллийн боловсруулалтыг хийсэн.

#### ЗУРАГ 3.5. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ХУУЛИЙН ЭТГЭЭД, 2011, 2016 ОН



Өмнөх тооллоготой харьцуулахад хуулийн этгээдийн тоо 27 нэгжээр буюу 48.2 хувиар өссөн байна.

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ



#### ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

Аж үйлдвэрийн салбарт уул уурхай, олборлолт, боловсруулах аж үйлдвэр, цахилгаан, хий,

дулаан үйлдвэрлэл, ус хангамж зэрэг үйлдвэрлэлийн дэд салбарыг хамруулан авч үзлээ.

Дээрх дэд салбарт хамрагдах аж ахуйн нэгжийн тооны эзлэх хувь хэмжээ болон эдийн засагт тэдгээрийн оруулж буй хувь нэмэр нь хоорондоо төдийлөн харилцан хамааралгүй

байдаг.

#### ХҮСНЭГТ 3.12. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНООР

ЭЗҮАА 4.0	2011		2016	
	Тоо	%	Тоо	%
<b>Нийт</b>	<b>37</b>	<b>100.0</b>	<b>60</b>	<b>100.0</b>
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	14	37.8	21	35.0
Ундаа үйлдвэрлэл	3	8.1	4	6.7
Нэхмэлийн үйлдвэрлэл	4	10.8	4	6.7
Хувцас үйлдвэрлэл	3	8.1	6	10.0
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4	10.8	5	8.3
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл; сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	4	10.8	1	1.7
Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	0	0.0	2	3.3
Резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл	0	0.0	1	1.7
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	2	5.4	9	15.0
Металл үйлдвэрлэл	0	0.0	1	1.7
Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1	2.7	2	3.3
Тавилга үйлдвэрлэл	0	0.0	2	3.3
Бусад боловсруулах үйлдвэрлэл	2	5.4	1	1.7
Машин, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт ба засвар	0	0.0	1	1.7

Боловсруулах үйлдвэрийн салбарын хуулийн этгээдийн тоо 2016 онд 60 аж

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

ажуйн нэгж болж, өмнөх тооллогоос 23 аж ахуйн нэгж буюу 37.8 хувиар, 2015 оны тооллогын дүнгээр үүнээс хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 21 аж ахуйн нэгж (35.0%), ундаа үйлдвэрлэл 4 аж ахуйн нэгж (6.7%), нэхмэлийн үйлдвэрлэл 4 аж ахуйн нэгж (6.7%), хувцас үйлдвэрлэл 6 аж ахуйн нэгж (10.0%), арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл 5 аж ахуйн нэгж (8.3%), төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл 9 аж ахуйн нэгж (15.0%) тус тус эзлэж байна.

#### ХҮСНЭГТ 3.13. ХУУЛИЙН ЭТГЭЭД АЖ АХУЙН НЭГЖ, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлийн төрлөөр

ЭЗҮАА	2016				
	Бүгд	Өөрийн эзэмшлийн	Түрээсийн	Бусад	Тогтсон байргүй
	<b>634</b>	<b>439</b>	<b>49</b>	<b>11</b>	<b>135</b>
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	80	37	0	1	42
Уул уурхай, олборлолт	1	0	0		1
Боловсруулах үйлдвэрлэл	60	41	10	1	8
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	12	10	0	1	1
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3	2	0	1	0
Барилга	42	27	3	1	11
Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	267	205	14	3	45
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	11	7	0	0	4
Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	34	24	7	0	3
Мэдээлэл, холбоо	6	5	0	0	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	7	4	0	0	3
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	4	4	0	0	0
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	63	46	5	1	11
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	10	6	0	1	3
Боловсрол	10	7	2	0	1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	20	11	7	1	1
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1	1	0	0	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3	2	1	0	0

Аж ахуйн нэгжүйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байрны эзэмшлийн төрлөөр авч үзвэл

### БҮЛЭГ III. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО, БАЙРШИЛ

өөрийн эзэмшлийн 439 аж ахуйн нэгж (69.2%), түрээсийн 49 аж ахуйн нэгж (7.7%), бусад 11 аж ахуйн нэгж (1.7%), тогтсон байргүй 135 аж ахуйн нэгж (21.2%) тус тус эзлэж байна.

#### МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ САЛБАР

Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын үйл ажиллагаа өргөжин тэлж, эдийн засгийн өсөлтийг хангахад зохистой хувь нэмэр оруулж ирсэн.

#### ХҮСНЭГТ 3.14. ТЭЭВЭР, АГУУЛАХ, МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭД САЛБАРААР

ЭЗҮАА 4.0	2011		2016	
	Тоо	%	Тоо	%
<b>Нийт</b>	<b>11</b>	<b>100.0</b>	<b>22</b>	<b>100.0</b>
ТЭЭВЭР БА АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	5	45.5	12	54.5
Хуурай замын тээвэр	5	45.5	11	50
Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа	0	0	1	4.5
МЭДЭЭЛЭЛ, ХОЛБОО	6	54.5	10	45.5
Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа	1	9.1	3	13.6
Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа	4	36.4	4	18.2
Цахилгаан холбоо	0	0	1	4.5
Компьютер програмчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа	1	9.1	2	9.1

Мэдээлэл, холбооны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд 2011 оны тооллогоос 4 аж ахуйн нэгж 34.0 буюу хувиар нэмэгдэж, 10 аж ахуйн нэгж болжээ. Үүнд, компьютер програмчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагааны дэд салбарын нэгж 2 буюу 20.0 хувь, цахилгаан холбоо 1 буюу 10.0 хувь, эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагааны дэд салбарын нэгжийн тоо 3 буюу 30.0 хувь, кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагааны дэд салбарын нэгж 4 буюу 40.0 хувийг эзлэж байна.


Мэдээлэл, холбооны салбарын хуулийн этгээдийг 2011 оны тооллогын дүнтэй харьцуулахад, эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагааны дэд салбарын мэдээлэл, холбооны салбарын нийт дүнд эзлэх хувь 4.4 пунктээр, цахилгаан холбоонийт дүнд эзлэх хувь 4.5 пунктээр, нэмэж харин кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааны дэд салбарын эзлэх хувь 18.2 пунктээр, ая үйлдвэрлэх үйл ажиллагааны дэд салбарын хувь 18.2 пунктээр буурсан байна.



а  
лэиэ  
04

4-0195

# ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ



**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ**

**ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ХЭЛБЭР**

Аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан хэлбэрийг "Компанийн тухай" Монгол Улсын хуулийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагын 2016 оны Улсын тооллогын асуулгын хуудас (ААНБТ-1)-т тусгасан. Аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан хэлбэрийг шинээр байгуулагдсан, өөрчлөн байгуулсан, нийлүүлсэн, нэгдсэн, хуваагдсан, тусгаарласан, өөрчлөн зохион байгуулагдсан гэж ангилан авч үздэг.

**ХҮСНЭГТ 4.1. ХУУЛИЙН ЭТГЭЭД АЖ АХУЙН НЭГЖ, үүсгэн байгуулагдсан хэлбэр, тооллого явагдсан оноор**

Үүсгэн байгуулагдсан хэлбэр	2006		2011		2016		2016 % 2011
	Бүгд	%	Бүгд	%	Бүгд	%	
Бүгд	261	99.9	305	100.1	634	100.2	207.9
Шинээр байгуулагдсан	219	83.9	289	94.8	601	94.8	208
Нийлүүлсэн	1	0.4	1	0.3	15	2.4	1500
Нэгдсэн	1	0.4	0	0	1	0.2	0
Хуваагдсан	3	1.1	0	0	1	0.2	0
Тусгаарласан	4	1.5	2	0.7	3	0.5	150
Өөрчлөн зохион байгуулагдсан	28	10.7	11	3.6	13	2.1	118.2
Бусад	5	1.9	2	0.7	0	0	0

Тооллогод хамрагдсан хуулийн этгээд аж ахуйн нэгжийн 94.8 хувь нь шинээр үүсгэн байгуулагдаж, үлдсэн 5.2 хувь нь бусад хэлбэр (нийлүүлсэн, нэгдсэн, хуваагдсан, тусгаарлагдсан, өөрчлөгдсөн)-ээр үүсгэн байгуулагдсан байна. Хуулийн этгээд аж ахуйн нэгжийн тоог үүсгэн байгуулагдсан хэлбэрт эзлэх хувийг өмнөх оны тооллогын дүнтэй харьцуулбал, нэмэгдсэн бол нийлүүлсэн хуулийн этгээд аж ахуйн нэгжийн тоо 2.1 пунктээр, нэгдсэн ААН нь 0.2 пунктээр, хуваагдсан 0.1 пунктээр нэмэгдэж тусгаарлагдсан

нь 0.2 пунктээр, өөрчлөн зохион байгуулагдсан ААН-ын хувьд 0.5 пунктээр, бусад хэлбэрээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд 0.7 пунктээр буурчээ. Харин шинээр байгуулагдсан ААН-н хувьд өөрчлөлтгүй байна

## БҮЛЭГ IV. ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

### ХҮСНЭГТ 4.2. ХУУЛИЙН ЭТГЭЭД АЖ АХУЙН НЭГЖ, үүсгэн байгуулагдсан хэлбэр, сумаар

Сум	Үүсгэн байгуулагдсан хэлбэр						
	Бүгд	Шинээр байгуулагдсан	Нийлүүлсэн	Нэгдсэн	Хуваасан	Тусгаарласан	Өөрчлөгдсөн
Бүгд	634	601	15	1	1	3	13
Есөнбулаг сум	338	328	1		1	2	6
Алтай сум	16	15		1			
Баян-Уул сум	15	14	1				
Бигэр сум	19	16					3
Бугат сум	18	15	1				2
Дарив сум	15	13	1			1	
Дэлгэр сум	31	24	7				
Жаргалан сум	16	16					
Тайшир сум	13	13					
Тонхил сум	12	12					
Төгрөг сум	16	16					
Халиун сум	19	18	1				
Хөхморьт сум	13	13					
Цогт сум	35	35					
Цээл сум	13	12					1
Чандмань сум	15	14	1				
Шарга сум	17	16					1
Эрдэнэ сум	13	11	2				

Хүснэгт 4.2-оос харахад хуулийн этгээд аж ахуйн нэгж шинээр үүсгэн байгуулагдах нь давамгайлсан байна.

### ХҮСНЭГТ 4.3. ХУУЛИЙН ЭТГЭЭД АЖ АХУЙН НЭГЖ, 2016 ОН, үүсгэн байгуулагдсан хэлбэр, хариуцлагын хэлбэрээр

Үүсгэн байгуулагдсан хэлбэр	Бүгд	Хариуцлагын хэлбэр					ТӨҮГ, ОНӨҮ Г	Бусад
		ХК	ХХК	Хоршоо	Нөхөрлөл			
БҮГД	634	3	479	114	28	10		
Шинээр байгуулагдсан	601	2	465	98	28	8		
Нийлүүлсэн	15		2	13				
Нэгдсэн	1			1				
Хуваагдсан	1		1					
Тусгаарласан	3		2			1		
Өөрчлөн зохион байгуулагдсан	13	1	9	2		1		
Бусад								

Хуулийн этгээд аж ахуйн нэгжийн үүсгэн байгуулагдсан хэлбэр бүрд ХХК нь голлох байр суурьтай байна. Тухайлбал, тооллогод хамрагдсан аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулагдсан

#### БҮЛЭГ IV. ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

болон хариуцлагын хэлбэрээр авч үзвэл, нийт 634 аж ахуйн нэгжээс 601 буюу 94.8 хувь нь шинээр үүсгэн байгуулагдсан ба тэдгээрийн 465 буюу 77.4 хувь нь ХХК байна.

